



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢ ᠰᠠᠲᠢᠰᠲᠢᠬᠢ ᠬᠡᠯᠲᠡᠰ

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ (2015 оны 1-р сард)



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠯᠢ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

Мал онд оролт: Мал сүргийн онд оролт 99.9 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 29.1 дахин бага байгаа ба 299 мал хорогджээ.

Үнэ: Хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн, малын үнэ сүүлийн сард харьцангуй тогтвортой байсан ба малчдын орлогын зонхилох хувийг бүрдүүлдэг ямааны ноолуурын үнэ түүвэр судалгаанд сонгогдсон Алтай хотод сарын эцэст доорхи ханштай байлаа.

Гол нэрийн барааны үнэ сумдад зах зээлийн зайнаас хамаарч харилцан адилгүй байгаагийн дээр аймгийн төвд гурил 1кг нь 1000-1200, сайн чанарын шар, цагаан будаа 2000-2200, элсэн чихэр 1800, ногоон цай 5000-6500 төгрөгийн дундаж ханштай байна.

Сар	I
1 кг ноолуурын үнэ (мянган төгрөг)	40.0



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

Аж үйлдвэр: Аж үйлдвэрийн салбарт 1 тэрбум 438.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 137.8 сая төгрөгөөр их байна. Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 79.2 хувь буюу 1 тэрбум 139.6 сая төгрөгийн борлуулалт хийгдлээ.

Төсвийн орлого: Орон нутгийн төсөвт 398.7 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 57.2, улсын төвлөрсөн төсөвт 25.7 сая төгрөг оруулж, аймгийн төсвийн нийт орлого 398.7 сая төгрөг биелэлттэй байна.



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

Хүн ам: Аймгийн хэмжээнд 119 эх амаржиж 122 хүүхэд мэнд төрлөө. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 17 тохиолдол бүртгэгдсэн байна. Халдварт өвчний гаралт өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор нэмэгдсэн байна.

Ажилгүйдэл: 1 сарын эцсийн байдлаар хөдөлмөр эрхлэхийг хүсч бүртгүүлсэн ажилгүйчүүд 1176 болсны дотор 55.6 хувь буюу 654 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгүүлсэн ажилгүйчүүдийн 244 нь дээд, 187 нь тусгай дунд, 435 нь бүрэн дунд, 145 нь суурь, 97 нь мэргэжлийн анхан шатны, 55 нь бага, 13 нь ямар ч боловсролгүй хүмүүс байна.



ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢ ᠬᠡᠯᠲᠡᠰ

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

www.1212.mn



Статистик мэдээлэл



@statistic_mn

Статистик мэдээлэл